



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хянаж боловсруулсан:

СЭШАЗГ-ын дарга А.Дэмбэрэл

Боловсруулсан:

СЭШАЗГ-ын ШСА-ны ахлах статистикч Ш.Ариунболд

СЭШАЗГ-ын ШСА-ны статистикч Н.Лхам

СЭШАЗГ-ын ШСА-ны ахлах шинжээч Ц.Янжиндулам

УЛААНБААТАР
2016 он

АГУУЛГА

НЭГ. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	3
Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, нэг км2 хавтгайд ногдох хүн ам, 2015 оны байдлаар	3
Хүн амын тоо, ҮНО, ДНБ-ий өсөлт, 2015 оны байдлаар_(Дэлхийн банкны орлогын болон бүс нутгийн ангиллаар)	4
Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал, төсөөлөл, 2013-2019.....	5
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЗАРИМ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ТҮВШНИЙ ХАРЬЦУУЛАЛТ	5
Хөгжлийн ижил түвшний орнуудын нэг хүнд ногдох үндэсний нийт орлого болон хүний хөгжлийн индексээр эзлэх байр, 2015.....	6
II.1 ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
ДНБ-д салбарын эзлэх хувь, 2014-2015	7
ДНБ-д салбарын эзлэх хувь, бүсийн ангиллаар, 2014.....	7
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, бууралт хувиар	8
Инфляцийн түвшин, хувиар (2010=100)	11
Улсын төсвийн (тусламжийг оруулаагүй) орлогын_дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	11
Улсын төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	12
Гадаад өрийн хэмжээ, тэрбум ам.доллараар	12
II.2 НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	13
Хүний хөгжлийн үзүүлэлтүүд.....	14
Хамран сургалтын бохир жин, хувиар.....	16
1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл	17
1000 амьд төрөлтөнд ногдох 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, тоогоор	17
Сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь	18
Улаанбурханы эсрэг урьдчилсан тарилгад_хамрагдалтын хувь.....	18
ГУРАВ. МОНГОЛ УЛС ДЭЛХИЙД.....	19
Монгол Улсын эрэмбэ	19
ДҮГНЭЛТ.....	20
Ашигласан материал.....	22

НЭГ. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн 130.0 сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 7 346 633 037 хүн¹ /2015 оны 12-р сарын 31-ний өдрийн 15 цагийн байдлаар/ амьдарч, нэг хавтгай дөрвөлжин километр дунджаар 56 хүн ногдож байна. Харин манай улсад 1.56 сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 3 057 800 хүн¹ мөн үеийн байдлаар амьдарч, нэг хавтгай дөрвөлжин километр дунджаар 2 хүн ногдож байна. Манай улс нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүн амын тоогоор нийт 214 орноос Гренландын дараа хоёрдугаарт орж байна.

НҮБ-ын “Хүний хөгжлийн тайлан-2015”-д хүний хөгжлийн индексээр манай улстай ойролцоо эрэмбэлэгдсэн Армен улсад 2015 оны байдлаар нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 106, Шри-Ланка улсад 334 хүн ногдож байна. Шри-Ланка улс нь манай улсаас 7 дахин их хүн амтай бол Армен улс нь хүн амын тоогоор ойролцоо байна. Мөн манай улсын хойд хөрш болох ОХУ-д нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 2015 оны байдлаар 9 хүн ногдож байхад, урд хөрш БНХАУ-д 146 хүн ногдож байна. Түүнчлэн Өмнөд Азийн орнууд бусад бүс нутагтай харьцуулахад нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүн амын тоогоор (нэг км² хавтгайд 366 хүн) тэргүүлж байна.

Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, нэг км² хавтгайд ногдох хүн ам, 2015 оны байдлаар

	Хүн ам, сая	Газар нутгийн хэмжээ, мян.км ²	Нэг км ² хавтгайд ногдох хүн ам
ДЭЛХИЙ	7 346.6	129 736.4	56
Монгол	3.0	1 564.1	2
Армен	3.0	29.7	106
Шри Ланка	21.0	65.6	334
ОХУ	144.1	17 098.3	9
БНХАУ	1 371.2	9 562.9	146
Зүүн Ази Номхон далайн орнууд	2 279.2	24 825.2	93
Европ, Төв Ази	907.9	28 460.4	33
Латин америк, Карибын тэнгисийн орнууд	633.1	20 425.5	32
Ойрх дорнод, Хойд Африкийн орнууд	424.1	11 370.8	38
Өмнөд Азийн орнууд	1 744.2	5 136.2	366
Сахар орчмын Африкийн орнууд	1 001.0	24 291.1	42
Хойд Америкийн орнууд	357.3	19 816.2	20

Эх үүсвэр: Дэлхийн банк, “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016”

Дэлхийн хэмжээнд 2015 онд 76.7 их наяд ам.долларын бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэсэн байна. Үүний 49.1 их наяд ам.доллар буюу 64.0 хувийг

¹ Эх үүсвэр: Дэлхийн банк, “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016”

дэлхийн нийт хүн амын 16.1 хувь амьдардаг өндөр орлоготой орнууд, 36.0 хувийг хүн амын 83.9 хувь амьдардаг бага болон дунд орлоготой орнууд үйлдвэрлэжээ.

Дэлхийн Үндэсний нийт орлого (ҮНО)-ын 24.6 хувийг АНУ дангаараа үйлдвэрлэж, дэлхийн эдийн засгийг тэргүүлсэн хэвээр байна. Үндэсний нийт орлогын хэмжээгээр эхний 5 байранд АНУ, БНХАУ, Япон, ХБНГУ, Англи улсууд (ҮНО-ын хэмжээ нь 2823.3-10723.9 тэрбум ам.доллар) орж байна. Нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээгээр Норвеги, Катар, Швейцарь, Люксембург, Австрали улсууд (Нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ нь 60.0-93.8 мянган ам.доллараар) тэргүүлж байна.

Монгол Улсын ҮНО-ын хэмжээ 2015 оны байдлаар 11.3 тэрбум ам.доллар болж 137-р байранд, нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ 3830 ам.доллар болж 141 дүгээр байранд орсон байна. Манай улс 2014 оны түвшнээс ҮНО-ын нийт хэмжээгээр 8 байраар урагшилж, нэг хүнд ногдох орлогоор 13 байраар ухарсан байна.

**Хүн амын тоо, ҮНО, ДНБ-ий өсөлт, 2015 оны байдлаар
(Дэлхийн банкны орлогын болон бүс нутгийн ангиллаар)**

	Хүн ам, сая	ҮНО*, тэрбум ам доллар	Нэг хүнд ногдох ҮНО*, ам доллар	ДНБ-ий жилийн өсөлт, хувиар
ДЭЛХИЙ	7 346.6	76 678.8	10437.3	2.5
I. Бага, дунд орлоготой орнууд	6 159.4	27 590.0	4479.3	3.6
I.1 Бага орлоготой орнууд	638.3	395.5	619.6	4.7
I.2 Дунд орлоготой орнууд	5 521.2	27 193.9	4925.4	3.5
I.2.1 Дундаас доогуур орлоготой орнууд	2 927.4	5 955.9	2034.5	5.5
Монгол	3.0	11.3	3830.0	2.3
Армен	3.0	11.7	3880.0	3.0
Шри Ланка	21.0	79.6	3800.0	4.8
I.2.2 Дундаас дээгүүр орлоготой орнууд	2 593.7	21 232.9	8186.2	3.0
II. Өндөр орлоготой орнууд	1 187.2	49 109.7	41366.3	1.9
Зүүн Ази Номхон далайн орнууд	2 279.2	21 885.8	9602.4	3.9
Европ, Төв Ази	907.9	21 924.1	24147.0	1.5
Латин америк, Карибын тэнгисийн орнууд	633.0	5 645.2	8918.7	-0.9
Ойрх дорнод, Хойд Африкийн орнууд	424.1	3 480.1	8206.5	2.9
Өмнөд Азийн орнууд	1 744.2	2 673.7	1532.9	7.2
Сахар орчмын Африкийн орнууд	1 001.0	1 629.8	1628.2	3.0
Хойд Америкийн орнууд	0.4	19 373.6	54216.7	2.3

Тайлбар: * - Атласын аргаар тооцсон
Эх үүсвэр: Дэлхийн банк, "Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016,"

Дээрх хүснэгтээс үзэхэд эдийн засгийн өсөлт 2015 онд хамгийн өндөр байгаа Өмнөд Азийн орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт дэлхийн дунджаас даруй 4.7 пунктээр, манай улсынхаас 4.9 пунктээр их байна.

Харин Зүүн Ази, Номхон далайн хөгжиж байгаа орнууд дэлхийн дунджаас 1.4 пунктээр, манай улсынхаас 1.6 пунктээр их байна.

Олон улсын банк санхүүгийн байгууллага дэлхийн голлох эдийн засгийн таамаглалыг Дэлхий, Евро бүс, АНУ, ОХУ, БНХАУ-аар гаргажээ. Уг таамаглалд дэлхийн эдийн засгийн өсөлт 2016 онд 3.2, 2017 онд 3.5, 2021 онд 3.6 байхаар төсөөлжээ. Мөн Азийн хөгжиж буй орнуудын эдийн засаг 2016-2018 онуудад буурах төлөвтэй байна гэж Олон улсын санхүүгийн байгууллагын шинжээчид үзжээ.

Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал, төсөөлөл, 2013-2019

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Гүйцэтгэл	Гүйц	Гүйц	Гүйц	Хүл.буй Гүйц	Төсвийн төсөөлөл		
Эдийн засгийн бодит өсөлт, хувь	11.6	7.9	2.3	3.0	3.4	4.3	6.8
Инфляц (ХҮИ-ээр илэрхийлсэн), хувь	12.5	11.0	1.9	7.0	7.0	7.0	7.0
Экспорт, сая ам.доллар	4269.1	5774.3	4669.5	3901.7	4228.9	4476.9	5352.4
Импорт, сая ам.доллар	6357.8	5236.6	3797.2	4309.8	4770.9	5011.3	5253.8

Эх үүсвэр: “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн танилцуулга”, Сангийн Яам, 2016 он

Монгол Улсын эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 2016-2030 онд дунджаар 6.6 хувь байхаар тусгасан.²

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЗАРИМ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЛОН УЛСЫН ТҮВШНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

Энэхүү судалгаанд Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг “Дэлхийн хөгжлийн үзүүлэлт”-2016, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс эрхлэн гаргадаг “Хүний хөгжлийн илтгэл”-2015 зэрэг баримт бичигт тусгагдсан эдийн засаг, нийгмийн статистик мэдээллийг 2000, 2005, 2010-2015 оноор авч, олон улсын түвшинд болон Монгол Улстай хөгжлийн ижил түвшний улсуудтай харьцуулав.

Дэлхийн банкнаас жил бүр улс орнуудыг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээнээс нь хамааруулан бага орлоготой, дунд орлоготой (дундаас доогуур болон дундаас дээгүүр), өндөр орлоготой гэж ангилдаг. Хамгийн сүүлд 2015 оны байдлаар атласын аргаар тооцсон ҮНО-ын хэмжээ нь 1025 ам.доллараас бага, 1026 ам.доллараас 4035 ам.долларын хооронд, 4036 ам.доллараас 12475 ам.долларын хооронд, 12476 ам.доллараас их байгаагаар нь ангилан 2016 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн бага, дундаас доогуур, дундаас дээгүүр, өндөр орлоготой гэсэн 4 ангилалд оруулсан байна. Манай улс 2014 онд дундаас дээш орлоготой орны тоонд багтсан боловч 2015 онд дундаас доогуур орлоготой орны ангилалд шилжсэн.


² Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батласан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”

Монгол Улс 2030 он гэхэд дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд орохоор зорьжээ.³

Түүнчлэн Дэлхийн банкнаас дээрх орлогын ангиллаас гадна бүс нутгийн орлогын ангиллаар дэлхийн улс орнуудыг 7 бүсд ангилдаг. Монгол Улс Зүүн Ази, Номхон далайн орнуудын ангилалд хамаардаг.⁴

Энэхүү харьцуулсан судалгаагаар манай улстай хөгжлийн ижил түвшний улсыг сонгохдоо нэг хүнд ногдох ҮНО-ын (худалдан авах чадварын паритетаар-ХАЧП) хэмжээ, хүний хөгжлийн индекс (ХХИ)-ээр ойролцоо үнэлэгдсэн Армен, Шри-Ланка зэрэг улсыг сонгосон.⁵

Хөгжлийн ижил түвшний орнуудын нэг хүнд ногдох үндэсний нийт орлого болон хүний хөгжлийн индексээр эзлэх байр, 2015



Эх үүсвэр: Дэлхийн банк, “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016”
НҮБХХ, “Хүний хөгжлийн илтгэл – 2015”

II.1 ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг “ Монгол Улсын статистикийн жилийн эмхэтгэл 2015 ”-д нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 7653.7 мян.төг (4028 ам.доллар), Дэлхийн банкны атласын аргаар тооцсоноор 4177 ам.долларт хүрсэн байна.⁶

Манай улсын үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2014 оны байдлаар 34.7 хувь байгаа нь Армен, Шри-Ланка улсынхаас 6.1 болон 4.1 пунктээр, дундаас доогуур орлоготой орнуудын дунджаас 3.5 пунктээр, дэлхийн дунджаас 7.1 пунктээр их байна. Үүнээс боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувь Армен, Шри-Ланка улсынхаас 1.1 болон 9.2 пунктээр, дундаас доогуур орлоготой орнуудын дунджаас 6.6 пунктээр, дэлхийн дунджаас 5 пунктээр бага байна.

³ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батласан “ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 ”

⁴ <http://data.worldbank.org/>

⁵ <http://hdr.undp.org/en/composite/HDI>

⁶ www.1212.mn

Хөдөө аж, ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувь Армен улсынхаас 6.1 пунктээр, дундаас доогуур орлоготой орнуудын дунджаас 1.6 пунктээр бага, дэлхийн дунджаас 10.8 пунктээр, өндөр орлоготой орнуудын дунджаас 13.2 пунктээр их байна.


Үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь Армен улсынхтай адил байгаа бөгөөд дундаас доогуур орлоготой орнуудын дунджаас 1.3 пунктээр, дэлхийн дунджаас 18 пунктээр бага байна.

ДНБ-д салбарын эзлэх хувь, 2014-2015

	Аж үйлдвэрлэлийн салбар		Үүний дотор боловсруулах үйлдвэр		Хөдөө аж ахуйн салбар		Үйлчилгээний салбар	
	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015
ДЭЛХИЙ	27.6	..	14.7	..	3.9	..	68.5	..
Бага орлоготой орнуудын дундаж	21.1	21.3	8.5	8.4	31.0	30.5	47.7	47.9
Дундаас доогуур орлоготой орнуудын дундаж	31.2	..	16.3	..	16.3	..	51.8	..
Армен	28.6	28.7	10.8	10.2	20.8	19.4	50.6	51.9
Монгол	34.7	34.1	9.7	9.1	14.7	14.8	50.5	51.1
Шри Ланка	30.6	30.7	18.9	19.5	8.6	8.7	60.8	60.6
Дундаас дээгүүр орлоготой орнуудын дундаж	35.8	34.1	7.3	7.1	56.9	58.6
Өндөр орлоготой орнуудын дундаж	24.7	..	14.8	..	1.5	..	73.9	..

Эх үүсвэр: Дэлхийн банк, "Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016"

ДНБ-д салбарын эзлэх хувь, бүсийн ангиллаар, 2014




Эх үүсвэр: Дэлхийн банк, "Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016"

ДНБ-ий салбарын бүтцийг бүс нутгаар авч үзвэл, Хойд Америкийн орнууд, Латин Америк, Карибын тэнгисийн орнууд болон Европ, Төв Азийн орнуудад ДНБ-ий 65-аас илүү хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна.

Монгол Улсын хувьд ч үйлчилгээний салбарын цар хүрээ үйлдвэрлэлийнхээс хурдацтай нэмэгдэж, 2014 онд ДНБ-ий 50.5 хувь, 2015 онд 51.1 хувь болжээ.

ДНБ-ий бодит өсөлтийг 2009-2015 оноор хөгжлийн ижил түвшний улсууд болон дэлхийн дундаж, бага болон дунд орлоготой орнуудын дундажтай харьцуулж үзвэл:

Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, бууралт хувиар



Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

2015 онд бага, дунд орлоготой орнуудын ДНБ-ий бодит өсөлтийн хурд дэлхийн дунджаас 1.3 пунктээр их байгаа бол дундаас дээгүүр орлоготой орнуудынх дэлхийн дунджаас 0.6 пунктээр их байна. Манай улсын хувьд 2011-2013 онд эдийн засгийн огцом өсөлттэй байсан бол сүүлийн жилүүдэд уул уурхай дахь хөрөнгө оруулалт болон бусад шалтгааны улмаас өсөлтийн хурд саарсан байна. Шри-Ланка улсын хувьд манай улсынхтай адил 2010-2012 онд эдийн засаг нь өндөр өсөлттэй байсан бол сүүлийн жилүүдэд өмнөх орнуудын өсөлтийг гүйцэхгүй байгаа хэдий ч дэлхийн дунджаас даруй 2.6 пунктээр их байна.

Эдийн засгийн өсөлтийг салбар тус бүрээр нь авч үзвэл:

Манай улсын хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт 2015 онд 10.7 хувь байгаа нь Армен улсынхаас 0.7 пунктээр бага, Шри-Ланка улсынхаас 5.2 пунктээр их байна. Харин дэлхийн дунджаас 7.8 пунктээр, дундаас дээгүүр орлоготой орнуудын дунджаас 7.2 пунктээр их байна.

Дундаас дээгүүр болон өндөр орлоготой орнуудын хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт нь нэг оронтой тоонд байсаар байна.

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт, бууралт хувиар

	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015
ДЭЛХИЙ	2.9	3.1	2.6	3.1	1.1	4.8	2.7	2.9
Бага орлоготой орнууд	0.5	6.2	4.7	1.9	7.0	1.9	4.6	4.2
Дундаас доогуур орлоготой орнууд	1.5	4.3	5.0	3.0	2.8	4.1	2.2	..
Монгол	-16.3	11.3	-16.6	-0.3	21.1	19.2	13.7	10.7
Армен	-1.1	11.3	-15.9	14.0	9.5	7.6	7.8	11.4
Шри Ланка	1.5	1.8	7.0	4.6	3.9	3.2	4.9	5.5
Дундаас дээгүүр орлоготой орнууд	2.8	4.2	3.6	4.8	2.1	4.5	3.0	3.5
Өндөр орлоготой орнууд	4.6	0.0	-1.4	0.4	-3.7	6.8	2.6	..

Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртгийн өсөлтийн хувьд манай улс тогтмол өндөр өсөлттэй байна. Харин 2011 оноос хойш дундаас доогуур орлоготой орнуудын дунджаас 3.2-7.8 пунктээр их байна. Хөгжлийн ижил түвшний Армен улсад 2000, 2005 онд үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлтийн хувь өндөр байсан бол 2014 онд бууралттай гарчээ. Өндөр орлоготой орнуудын хувьд энэ өсөлт удаашралтай байна.

Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт, бууралт хувиар

	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015
ДЭЛХИЙ	4.8	3.4	7.1	3.8	2.3	2.4	2.9	..
Бага орлоготой орнууд	3.5	7.7	7.8	9.5	6.2	9.4	7.1	4.7
Дундаас доогуур орлоготой орнууд	6.4	6.1	6.0	5.6	4.0	4.2	4.6	..
Монгол	1.5	4.2	4.3	8.8	14.8	14.6	12.7	8.8
Армен	23.7	14.8	7.4	1.8	5.0	0.5	-2.2	2.5
Шри Ланка	7.2	8.0	8.4	9.3	9.0	4.1	3.5	3.0
Дундаас дээгүүр орлоготой орнууд	6.6	7.1	9.4	7.1	4.8	4.8	4.2	3.3
Өндөр орлоготой орнууд	4.0	1.6	6.1	1.7	0.6	0.8	1.8	..

Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Манай улсын үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт дундаас доогуур орлоготой орнуудын дундажтай харьцуулахад 2011 онд 10.7 пунктээр, 2014 онд 0.7 пунктээр их гарчээ.

Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт, бууралт хувиар

	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015
ДЭЛХИЙ	3.9	4.0	3.2	3.0	2.6	2.2	2.6	..
Бага орлоготой орнууд	2.2	5.1	8.5	7.8	8.1	6.1	6.6	5.8
Дундаас доогуур орлоготой орнууд	4.7	8.4	7.9	7.1	6.7	6.5	7.1	..
Монгол	4.4	10.7	6.6	17.8	10.3	7.8	7.8	1.1
Армен	-6.3	15.7	4.8	3.4	7.2	3.2	5.7	1.8
Шри Ланка	6.7	6.4	8.0	8.9	11.2	3.8	5.2	5.3
Дундаас дээгүүр орлоготой орнууд	5.6	7.7	6.7	6.4	5.2	4.9	4.2	3.8
Өндөр орлоготой орнууд	3.6	3.1	1.9	1.8	1.5	1.1	1.7	..

Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Манай улсын боловсруулах салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт 2000, 2005 онд сөрөг гарсан. Харин 2010-2015 онд өсөлттэй гарсанаас 2013 онд хамгийн өндөр өсөлттэй байна. Дундаас доогуур орлоготой орнуудтай харьцуулахад өсөлтийн хувь өндөр байна. Армен улсын хувьд боловсруулах салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт 2014 он хүртэл эерэг байсан бол 2015 онд сөрөг гарчээ.


Боловсруулах салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт, бууралт хувиар

	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015
ДЭЛХИЙ	5.5	3.3	9.4	2.8	0.8	1.5	2.0	..
Бага орлоготой орнууд	-2.5	6.6	5.1	6.2	5.2	7.9	4.6	8.5
Дундаас доогуур орлоготой орнууд	6.3	6.9	6.3	4.9	5.4	7.1	3.9	..
Монгол	-3.7	-19.1	6.1	7.9	8.7	10.3	4.2	1.3
Армен	6.6	8.8	12.1	13.7	4.1	7.7	5.6	-3.6
Шри Ланка	9.2	6.2	7.3	3.5	3.2	2.3	2.9	4.1
Дундаас дээгүүр орлоготой орнууд
Өндөр орлоготой орнууд	5.9	2.7	9.9	2.2	0.1	0.7	2.0	..

Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Манай улсын инфляцийн жилийн дундаж түвшин 2015 онд өмнөх оныхоос 9 пунктээр, 2010 оныхоос 63.5 пунктээр өссөн байна. Харьцуулалтад сонгож авсан Армен улсын хувьд 2015 онд өмнөх оныхоос 4.5 пунктээр, 2010 оныхоос 24.8 пунктээр өссөн байна, харин Шри-Ланка улсын хувьд 2015 онд өмнөх оныхоос 1.2 пунктээр, 2010 оныхоос 27.9 пунктээр өссөн байна.


Инфляцийн түвшин, хувиар (2010=100)



Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Улсын төсвийн (тусламжийг оруулаагүй) орлогын ДНБ-д эзлэх хувийг доорх хүснэгтээр үзүүлэв. Манай улсын хувьд Улсын төсвийн (тусламжийг оруулаагүй) орлогын ДНБ-д эзлэх хувь 2012 онд Армен, Шри-Ланк улсынхаас 3.0 болон 13.6 пунктээр их байна.


Улсын төсвийн (тусламжийг оруулаагүй) орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



Эх үүсвэр: Дэлхийн банк, "Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016"

ДНБ-д улсын төсвийн орлого, зарлагын эзлэх хувь нь эдийн засаг дахь төрийн оролцоог харуулна. Засгийн газрын зардал ДНБ-ий 30 хувиас давах нь урт хугацаанд эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөлдөг болохыг алдарт эдийн засагч, судлаач Р.Ж.Вагго эмпирик судалгаагаар нотолсон байдаг. Манай улсын хувьд Улсын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2015 онд 11.9 болсон нь 2000, 2005, 2010-2015 оны хамгийн бага үзүүлэлт байна.

Улсын төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



Эх үүсвэр: Дэлхийн банк, “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2016”

Гадаад өрийн хэмжээ нь тухайн улсын зээлжих зэрэглэл болон хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтанд нөлөөлдөг гол үзүүлэлт юм. Хөгжиж буй орнуудын туршлагаар зээлийн хэмжээний өнөөгийн утга нь нийт экспортын 200 хувьд хүрэхэд өр төлбөрийн хүндрэл үүсдэг болох нь тогтоогдсон. Үүнээс гадна зарим үзүүлэлт гадаад өрийн тогтвортой байдлыг илэрхийлдэг. Үүнд: а) нийт өр ба ДНБ-ий харьцаа б) засгийн газрын өр төсвийн орлогын харьцаа в) нийт өрөнд эзлэх концессийн өрийн эзлэх хэмжээ гэх мэт.⁷

Манай улс 2016-2030 онуудад өрийн удирдлагын оновчтой тогтолцоог хөгжүүлж, гадаад өрийн ачааллыг зохистойгоор удирдаж, өрийн дээд хязгаарыг чанд баримтлан, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 40 хувиас хэтрүүлэхгүй байхаар тусгасан.⁸

Гадаад өрийн хэмжээ, тэрбум ам.доллараар

	2000	2005	2010	2011	2012	2013	2014
Бага орлоготой орнууд	89.5	101.3	97.5	104.8	113.5	126.2	139.4
Дундаас доогуур орлоготой орнууд	503.5	547	848.9	928.8	1 028.9	1 146.6	1 249.0
Монгол	0.8	1.3	5.3	8.8	14.2	17.2	18.4
Армен	0.7	1.4	4.8	5.5	5.9	6.8	7.1
Шри Ланка	8.3	10	17.4	20	26.2	30.7	34.4
Дундаас дээгүүр орлоготой орнууд	868.1	974	1 626.5	1 814.5	2 027.6	2 220.3	2 382.1

Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

⁷ <http://data.worldbank.org/indicator/DT.DOD.DECT.GN.ZS>


⁸ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батласан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”

Гадаад өрийн экспортод эзлэх хувь

	2000	2005	2010	2011	2012	2013	2014
Бага орлоготой орнууд	329.2	208.6	109.1	97.7	98.0	100.2	..
Дундаас доогуур орлоготой орнууд	172.7	102.9	96.4	87.0	94.3	99.7	104.8
Монгол	153.2	93.5	173.2	175.6	284.8	375.6	325.1
Армен	183.4	101.3	193.4	194.5	189.4	196.5	188.7
Шри Ланка	141.6	141.9	190.5	183.5	261.0	264.7	258.2
Дундаас дээгүүр орлоготой орнууд	99.3	65.0	64.5	60.6	63.5	67.9	70.3

Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь



Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

II.2 НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Манай улс дэлхийн банкны орлогын ангиллаар 2016 онд дундаас доогуур орлоготой орнуудын ангилалд багтсан ба далайд гарцгүй хөгжиж буй орон гэж тодорхойлогддог. Олон улсын байгууллагууд сүүлийн жилүүдэд нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг Мянганы Хөгжлийн зорилттой уялдуулан боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтийг голлон авч үзэх болсон.

Монгол Улс “Хүний Хөгжлийн Илтгэл”-ийг Монгол дахь НҮБХХ-ийн газрын дэмжлэгтэйгээр 1997 онд “Монгол хүн ба хүний хөгжил” сэдвийн хүрээнд анх удаа гаргасан. Түүнээс хойш 2000 онд “Төрийг шинээр зүглүүлэхүй”, 2003 онд “Хот, хөдөөгийн ялгаатай байдал”, 2007 онд “Хөдөлмөр эрхлэлт ба ядуурал”, 2011 онд “Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү”, 2016 онд “Ирээдүйн сайн сайхны төлөө: Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо” сэдвүүдээр илтгэлүүдийг гаргасан.

Хүний хөгжлийн үзүүлэлтүүд

ХХ-ийн эрэмбэ		Хүний хөгжлийн индекс (ХХИ)	Дундаж наслалт, жилээр	Сургуульд суралцахаар хүлээгдэж буй хугацаа, жилээр	Сургуульд суралцсан дундаж хугацаа, жилээр	Нэг хүнд ногдох ҮНО*, ам.долл
73	Шри Ланка	0.757	74.9	13.7	10.8	9 779
85	Армен	0.733	74.7	12.3	10.9	8 124
90	Монгол	0.727	69.4	14.6	9.3	10 729
	Хүний хөгжлийн ангиллаар					
	Хүний хөгжлөөр маш өндөр	0.896	80.5	16.4	11.8	41 584
	Хүний хөгжлөөр өндөр	0.744	75.1	13.6	8.2	13 961
	Хүний хөгжлөөр дунд	0.630	68.6	11.8	6.2	6 353
	Хүний хөгжлөөр доогуур	0.505	60.6	9.0	4.5	3 085
	Хөгжиж буй орнууд бүсээр	0.660	69.8	11.7	6.8	9 071
	Арабын орнууд	0.686	70.6	12.0	6.4	15 722
	Зүүн ази номхон далайн орнууд	0.710	74.0	12.7	7.5	11 449
	Европ төв ази	0.748	72.3	13.6	10.0	12 791
	Латин америк карибын тэнгисийн орнууд	0.748	75.0	14.0	8.2	14 242
	Өмнөд азийн орнууд	0.607	68.4	11.2	5.5	5 605
	Сахар орчмын африкийн орнууд	0.518	58.5	9.6	5.2	3 363
	Буурай хөгжилтэй орнууд	0.502	63.3	9.3	4.1	2 387
	Хөгжиж буй орны жижиг арлууд	0.660	70.1	11.4	7.9	6 991
	Эдийн засаг хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага	0.880	80.2	15.8	11.5	37 658
	Дэлхийн дундаж	0.711	71.5	12.2	7.9	14 301

*Эх үүсвэр: НҮБХХ, Хүний хөгжлийн илтгэл – 2015
Тайлбар: * худалдан авах чадварын паритетаар илэрхийлсэн*


НҮБ-аас эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хүний хөгжил улам бүр чухал болж байгааг тодорхойлох зорилгоор үндэсний хүний хөгжлийн илтгэлийг гаргаж байхыг гишүүн орнууддаа уриалан, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) 1990 онд дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлийг боловсруулсан.

Монгол хүний хөгжлийн индекс 2009 онд 0.642 байсан бол “Хүний хөгжлийн илтгэл 2015”-д үзүүлснээр 2014 онд 0.727 болж хүний хөгжлөөр өндөр орнуудын тоонд багтсан.

“Хүний хөгжлийн илтгэл 2011”-д Монгол Улс хүний хөгжлийн индексээрээ 110-р байранд байсан бол “Хүний хөгжлийн илтгэл 2015”-д 90-дүгээр байранд орж 20 байраар урагшилжээ.

Дэлхийн хүн амын өсөлт 2005 онд 1.2 хувь байсан бол 2015 онд мөн 1.2 хувьтай болж, өсөлт тогтвортой байна. Манай улсын хүн амын жилийн дундаж өсөлт 2015 онд 2005 оныхоос 0.5 пунктээр өссөн, Шри-Ланк улсынх 0.1 пунктээр өсч, Армен улсынх 0.8 пунктээр буурчээ. Манай улсын хүн амын жилийн дундаж өсөлт 2015 оны байдлаар дэлхийн дунджаас 0.5 пункт, өндөр орлоготой орнуудын дунджаас 1.3 пунктээр өндөр байна.

Хүн амын жилийн дундаж өсөлт, хувиар



Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Монгол Улсын хамран сургалтын бохир жин бага, дунд, дээд боловсролын түвшинд 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 1.3-27.7 пунктээр өссөн байна. Дээд боловсролын хамран сургалтын бохир жин 2010 оны байдлаар өндөр орлоготой оронтой харьцуулахад 12.9 пунктээр бага байгаа хэдий ч дэлхийн дундажтай харьцуулахад 24.5 пунктээр их, дундаас дээгүүр орлоготой орнуудын дунджаас 23.4 пунктээр их, дундаас доогуур орлоготой орнуудын дунджаас 34.7 пунктээр их, хөгжлийн ижил түвшний орнуудтай харьцуулахад Армен улсынхаас 3.2, Шри-Ланка улсынхаас 37.5 пунктээр тус, тус их байна.

Хамран сургалтын бохир жин, хувиар

	2000			2005			2010		
	Бага	Дунд	Дээд	Бага	Дунд	Дээд	Бага	Дунд	Дээд
ДЭЛХИЙ	98.4	59.4	19.0	105.0	63.8	24.1	108.3	71.1	29.3
Бага орлоготой орнууд	81.4	30.2	4.2	96.5	34.6	5.3	104.8	42.2	8.4
Дундаас доогуур орлоготой орнууд	95.8	47.5	11.9	103.7	54.3	14.0	105.8	62.2	19.1
Монгол	99.0	65.1	30.2	98.0	90.3	44.7	125.7	91.6	53.8
Армен	98.5	90.7	34.9	94.3	91.1	38.4	50.6
Шри-Ланка	99.6	99.7	96.9	16.3
Дундаас дээгүүр орлоготой орнууд	107.2	67.5	15.1	113.3	72.3	23.7	117.3	84.9	30.4
Өндөр орлоготой орнууд	101.4	97.7	56.1	100.5	97.9	66.4	101.8	99.2	72.9


Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Манай улсын 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2015 оны байдлаар дэлхийн дунджаас 12.7-аар, 5 хүртэлх насны хүүхдийн 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл дэлхийн дунджаас 20.1-аар бага байна. Хөгжлийн ижил түвшний улс болох Армен улсынхтай харьцуулахад 1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл 6.4-аар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 10.6-аар их байна. Харин Шри-Ланка улсынхтай харьцуулахад 1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл 8.3-аар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 12.6-аар их байна.

Манай улс 1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдлийг 2016-2030 онд дунджаар 8 болгохоор тусгасан.⁹ Энэ нь 2015 оны үзүүлэлтээс 14.4-өөр бага түвшин юм.


⁹ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батласан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”

1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл



Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

1000 амьд төрөлтөнд ногдох 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, тоогоор




Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Манай улсын сүрьеэг илрүүлж эмчилсэн тохиолдлын хувь 2013 онд дэлхийн дундажтай харьцуулахад 3.0 пунктээр их байна.

Улаанбурханы эсрэг урьдчилан сэргийлэх тарилгад 2015 оны байдлаар 12-23 сартай хүүхдүүдийн 98.0 хувийг хамруулсан нь дэлхийн дундажтай харьцуулахад 13.2 пунктээр их байна.


Манай улс урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдалтын хувийг 2016-2030 онд дунджаар 99.8 байхаар тусгасан.¹⁰

Сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь



Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Улаанбурханы эсрэг урьдчилсан тарилгад хамрагдалтын хувь



Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

¹⁰ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батласан “ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 ”

ГУРАВ. МОНГОЛ УЛС ДЭЛХИЙД

Дэлхийн банк, Нэгдсэн үндэсний байгууллага, Дэлхийн эдийн засгийн форум, Эдийн засгийн энхтайвны институт, Олон улсын хүнсний бодлогын институт, "Экономист" сэтгүүл, Хүүхдийг хамгаалах олон улсын байгууллага, "New economics" сан зэрэг байгууллагаас эрхлэн гаргадаг тайланд манай улсын ҮНО-ын хэмжээ болон бусад өрсөлдөх чадварын индексийг тодорхойлж, дэлхийн орнуудтай харьцуулан гаргадаг.

Монгол Улсын эрэмбэ

Тайлан гаргасан байгууллага	Индекс	Хамрах хугацаа	Оноо	Эрэмбэ
1 Дэлхийн банк	Нэг хүнд ногдох ҮНО, атласын аргаар тооцсон	2015	3830 ам доллар	217 орноос 141-д
2 Дэлхийн банк	Нэг хүнд ногдох ҮНО,ХАЧП-аар тооцсон	2015	11070 ам доллар	216 орноос 121-д
3 Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр	Хүний хөгжлийн индекс	2015	0.727	182 орноос 90-д
4 Дэлхийн эдийн засгийн форум	Өрсөлдөх чадварын индекс	2014-2015	3.81	144 орноос 98-д
5 Эдийн засаг, энх тайвны институт	Энх тайвны индекс	2015	1.706	162 орноос 43-д
6 Олон улсын хүнсний бодлогын институт	Өлсгөлөнгийн индекс	2015	14.7	104 орноос 49-д
7 "Экономист" сэтгүүл	Ардчиллын индекс	2015	6.6	167 орноос 56-д
8 Хүүхдийг хамгаалах олон улсын байгууллага	Хүүхдийн хөгжлийн индекс	2005-2010	0.759	134 орноос 59-д
9 "New economics" сан	Аз жаргалын индекс	2016	14.3	140 орноос 136-д

Эх үүсвэр: Дэлхийн банк, <http://data.worldbank.org/>

Манай улс 2030 он гэхэд нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээг 17500 ам. долларт хүргэх, хүний хөгжлийн үзүүлэлтээр эхний 70-д багтах, өрсөлдөх чадварын индексээр эхний 70-д багтах, ядуурлын бүх төрлийг эцэс болгох, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болох зорилтуудыг дэвшүүлсэн.¹¹

¹¹ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батласан “ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 ”

ДҮГНЭЛТ

1. Монгол Улс 2015 онд хүний хөгжлөөр өндөр орнуудын тоонд багтсан. Гэсэн хэдий ч анхаарал хандуулах шаардлагатай дараах асуудлууд байна. Үүнд: хүн амын дундаж наслалт, нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээ, нялхсын болон 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, орчны бохирдол зэрэг анхаарал татсан асуудлууд багтаж байна.

2. Манай улс дундаж наслалтаараа хүний хөгжлөөр өндөр орнуудын дунджаас 5.7-аар бага байгаа бөгөөд атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээгээр хүний хөгжлөөр өндөр орнуудын дунджаас 3232 ам.доллараар бага байна. Дэлхийн банкны хөгжлийн хөтөлбөрт тусгаснаар манай орны 5-аас доош насны 100000 хүүхдэд ногдох нас баралтын шалтгаан:

- Гадаад орчны бохирдлын нөлөөллөөс шалгаалсан 5-аас доош насны 100000 хүүхдэд ногдох нас баралт 19 байгаа нь хүний хөгжлөөр өндөр орнуудын дунджаас 17-оор их байна.
- Дотоод орчны бохирдол буюу нүүрстөрөгчийн исэл (угаарын хий), дам тамхидалт, харшил, хортон шавьж устгах бодис гэх мэтээс шалтгаалсан 5-аас доош насны 100000 хүүхдэд ногдох нас баралт 78 байгаа нь хүний хөгжлөөр өндөр орнуудын дунджаас 68-аар их байна.
- Бохир ус, цэвэрлэх байгууламж, эрүүл ахуйн шаардлага хангаагүй зэргээс шалтгаалсан 5-аас доош насны 100000 хүүхдэд ногдох нас баралт 198 байгаа нь хүний хөгжлөөр өндөр орнуудын дунджаас 138-аар их байна.

Манай улсад 2010 оны байдлаар хүн амын 31.5 хувь нь хөрсний доройтолд орсон газар амьдарч байна.¹²

Иймд хүн амын урт удаан, сэтгэл хангалуун амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэхийн тулд орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх, эрүүл мэнд боловсролын үйлчилгээг сайжруулах, ДНБ-д эзлэх эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний зардлын хувийг нэмэгдүүлэх, ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна.

3. Монгол Улсын өрсөлдөх чадвар сүүлийн 4 жил харьцангуй тогтвортой буюу өрсөлдөх чадварын индекс 3.7-3.9 хооронд байсан ба 93-107 дугаар байранд эрэмбэлэгдсэн. Үүнд макро эдийн засгийн орчин, санхүүгийн зах зээлийн хөгжил, инноваци, бизнесийн шинэ санаа зэргийн үзүүлэлт тааруу байгаа нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн манай улсад бизнес хийхэд тулгардаг гол асуудлуудад Засгийн газрын хүнд суртал, гадаад валютын зохицуулалт, ажиллах хүчний чадвар муу, инфляцийн түвшин, бодлогын тогтвортой бус байдал зэрэг нь голлох 5 хүчин зүйлд орсон байна.

“ МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030 ” –ийн зорилтыг хангахын тулд дээрх үзүүлэлтийг сайжруулах арга хэмжээг авах шаардлагатай тулгарч байна. Иймд макро эдийн засгийн орчныг сайжруулах;

¹² “Human Development Report-2015” – UNDP

инноваци, шинэ санааг дэмжих; санхүүгийн нөөц боломжийг нэмэгдүүлэх; бодлогын тогтвортой байдлыг хангах; хүнд суртал, авилгыг бууруулахад чиглэгдсэн бодит үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол, МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030, <https://mof.gov.mn>
2. Монгол Улсын Сангийн Яам, “ Монгол улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн танилцуулга”-2016 он
<http://www.parliament.mn/news/open/categories/2453/pages/30721>
3. Монгол банк, судалгааны ажил,
4. “Статистикийн эмхэтгэл - 2015” – ҮСХ, www.1212.mn, www.nso.mm
5. “World development indicators – 2016” – WB, updated by 4th of October 2016
6. “World Economic Prospects – 2016” – WB
7. “Human Development Report-2015” – UNDP
8. <http://data.worldbank.org/>, WB
9. <http://sdbs.adb.org/>, ADB
10. <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/23969/9781464806834.pdf>
11. <http://hdr.undp.org/en/composite/HDI>
12. <https://www.conference-board.org/data/globaloutlook/>